



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,  
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН  
ТОГТООЛ

2019 оны 01 сарын 08 өдөр

Дугаар 16

Улаанбаатар хот

Шалгалтын мөрөөр авах арга  
хэмжээний тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 1, 2, 66 дугаар зүйлийн 3 дахь хэсгийг тус тус үндэслэн “Багануурын дулааны станц” ТӨХК-ийн 2016 он, 2017 оны санхүү, эдийн засгийн үйл ажиллагаанд хийсэн баримтын шалгалтаар нийт 557,9 сая төгрөгийн зөрчил, дутагдал илэрснийг тэмдэглэн ТОГТООХ нь:

1. “Багануурын дулааны станц” ТӨХК-ийн 2016 он, 2017 оны санхүү, эдийн засгийн үйл ажиллагаанд хийсэн шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдал, түүнийг арилгах арга хэмжээний жагсаалтыг хавсралтаар баталсугай.

2. Дараах арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг “Багануурын дулааны станц” ТӨХК-ийн Гүйцэтгэх захирал Н.Ганбаатарт үүрэг болгосугай:

2.1. Шалгалтын тайланд дурдсан зөрчил, дутагдлыг нэн даруй арилгах арга хэмжээ авах;

2.2. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, Сангийн сайдын 2017 оны 363 дугаар тушаалаар батлагдсан “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам”-ыг худалдан авах ажиллагаанд мөрдөж ажиллах;

2.3. Санхүүгийн үйл ажиллагаанд Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д заасан “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 6.4.2-д заасан “Төрийн чиг үүрэгт хамаарахгүй хөтөлбөр, арга хэмжээг санхүүжүүлэхгүй байх” зарчмыг баримтлан, Засгийн газрын 2018 оны “Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн талаар авах арга хэмжээний тухай” 8 дугаар тогтоолыг хэрэгжүүлэх;

2.4. Мөнгөн кассын үйл ажиллагаанд Сангийн сайдын 2012 оны 276 дугаар тушаалаар батлагдсан мөнгөн кассын үйл ажиллагааны журмыг мөрдөх, бага хэмжээний үнийн дүнтэй бараа, ажил, үйлчилгээний болон банкны харилцах дансгүй этгээдийн төлбөрөөс бусад тохиолдолд мөнгөн гүйлгээг бэлэн мөнгөөр гүйцэтгэх явдлыг зогсоох;

2.5. Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7 дахь хэсгийг мөрдөж, засваргүй, үнэн зөв хөтлөгдсөн, бүрдлийг хангасан санхүүгийн баримтаар зарлагын гүйлгээ хийж, санхүүгийн тайланд тусгаж байх;

2.6. Шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдлыг арилгах талаар өгсөн үүрэг, даалгаврын биелэлтийг 2019 оны 1 дүгээр улиралд багтаан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, хяналтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-т даалгасугай.

ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР  
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ


  
Б. ГАНБАТ

ЗАХИРГАА, ХУУЛЬ ЗҮЙН  
ХЭЛТСИЙН ДАРГА

  
Б. ГАВАА

0000007

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын  
2018 оны 9 дугаар сарын 29 ний өдрийн  
6 дугаар тогтоолын хавсралт



Шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдал, түүнийг арилгах арга хэмжээний жагсаалт

№	Зөрчил, дутагдлын утга	Хариуцах эзэн	Дүн /мян.төгрөг/	Зөрчил дутагдлыг арилгах талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээ
1	Батлагдсан төлөвлөгөөгүй зохион байгуулсан худалдан авах ажиллагаа	Захирал Н.Ганбаатар Ерөнхий ня-бо Ц.Энхцэцэг	243,791.5	Сангийн сайдын 2017 оны 363 дугаар тушаалаар батлагдсан "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам"-ыг мөрдөж ажиллах
2	Зөвшөөрөлгүй бэлтгэсэн хөрөнгийн талаар:	Захирал Н.Ганбаатар Ерөнхий ня-бо Ц.Энхцэцэг	31,420.00	Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийг мөрдөж ажиллах
3	"Төрийн болон орон нутгийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай" хууль зөрчин худалдан авалт хийсэн	Захирал Н.Ганбаатар Ерөнхий ня-бо Ц.Энхцэцэг	89,103.80	"Төрийн болон орон нутгийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай" хуулийг мөрдөж ажиллах
4	Гэрээ хэлцэлгүй худалдан авсан ажил үйлчилгээ	Захирал Н.Ганбаатар Ерөнхий ня-бо Ц.Энхцэцэг	105,649.76	Монгол Улсын Иргэний хуулийн холбогдох заалтыг мөрдөж ажиллах
5	Захиалгын хуудасгүй бэлтгэсэн сэлбэг хэрэгслэл, бараа материал	Захирал Н.Ганбаатар Ерөнхий ня-бо Ц.Энхцэцэг	87,965.06	Бараа материал бэлтгэх журам боловсруулж, мөрдөж ажиллах
	<b>Дүн</b>		<b>557,930.12</b>	